Улсын ерөнхий прокурорын 2026 оны
06 дугаар сарын 09-ний өдрийн
А/95 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

√	Прокурорын байгууллагын бүтцийг шинэчлэн батлагдсан

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:	Төрийн албаны тухай хууль 2017-12-07
Дагаж мөрдөх огноо:	2019-01-01
Албан тушаалын тодорхойлолтыг батлагдсан огноо:	2026-06-09

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
Улсын ерөнхий прокурорын газар	Прокурорын хараат бус, аюулгүй байдлыг хангах хэлтэс
Албан тушаалын нэр:	**Албан тушаалын ангилал, зэрэглэл:**
Прокурорын хараат бус, аюулгүй байдлыг хангах хэлтсийн дарга, ахлах прокурор	Төрийн тусгай
Ажлын цаг:	**Ажлын байрны албан ёсны байршил:**
Ажлын өдрийн 8 цаг	Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу, Хуульчдын гудамж 15/1
Хөдөлмөрийн нөхцөл:	**Онцгой нөхцөл:**
Хэвийн	Хамаарахгүй

II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Прокурорын хараат бус, аюулгүй байдлыг хангах чиглэлээр баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулах, прокурор, ажилтны сахилга, ёс зүйтэй холбоотой зөрчилд явуулах шалгалт, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх ажлыг зохион байгуулах.

Албан тушаалын зорилт:

1.Прокурорын хараат бус байдал, прокурорын байгууллага, прокурор, ажилтны аюулгүй байдлыг хангах чиглэлээр баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулах;

2.Прокурор, ажилтны сахилга, ёс зүйтэй холбоотой зөрчилд явуулах шалгалт, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх ажлыг зохион байгуулах;

3.Хэлтсийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, гүйцэтгэлд хяналт тавих.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах- Т, Хариуцан гүйцэтгэх- Г Хянах- Х Шийдвэрлэх- Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1.Прокурорын хараат бус, аюулгүй байдлыг хангах чиглэлээр баримтлах бодлогыг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулах.	Бодлого, чиглэлийг тодорхойлж, арга хэмжээ авсан байна.	Г, Х, Ш
	1.2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төсөлд санал боловсруулж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах.	Төлөвлөлтийг оновчтой хийж, биелэлтийг хангуулсан байна.	Г, Х
	1.3.Хууль, дүрэм, журам, зааврын төсөл, мэдээлэл, санал, албан бичигт санал, тайлбар өгөх, зохион байгуулалтын шаардлагатай бусад арга хэмжээ авах.	Хууль, дүрэм, журам, зааврын төсөл, мэдээлэл, албан бичигт өгсөн санал хууль зүйн үндэслэлтэй байна.	Г, Х
	1.4.Прокурор бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь саад учруулсан, нэр төр, хараат бус байдалд халдсан, аливаа хэлбэрээр дарамт шахалт үзүүлсэн тохиолдлыг судлуулж, авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг танилцуулах.	Судалгаа хийж, санал танилцуулсан байна.	Х
	1.5.Прокуророос гаргасан нөлөөллийн мэдүүлгийг холбогдох журамд заасны дагуу бүртгэлд авч, шаардлагатай бол хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах.	Журмын хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Г, Х
	1.6.Тусгай зориулалтын автомашин ашиглуулах ажлыг хариуцан зохион байгуулах, албаны автомашины хөдөлгөөнд хяналт тавих.	Зохион байгуулалтыг хангаж, хяналт тавьсан байна.	Х
	1.7.Прокурорыг нэг бүрийн тусгай хэрэгслээр хангах, хадгалах, хэрэглэх үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах.	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулсан байна.	Г, Х
	1.8. Прокурорын байгууллага, прокурор, ажилтны аюулгүй байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор	Холбогдох арга хэмжээ авч, хамтран ажилласан байна.	Г

	холбогдох арга хэмжээ авах, бусад байгууллагатай хамтран ажиллах.		
	1.9.Прокурорын байгууллагын мэдээллийн систем, дэд бүтэц, нэгдсэн сүлжээний нууцлал, аюулгүй байдлын чиглэлээр цахим хөгжил, мэдээлэл технологи хариуцсан нэгжтэй хамтран ажиллах.	Байгууллагын мэдээллийн дотоод сүлжээний нууцлал, аюулгүй байдал хангагдсан байна.	Г, Х
	1.10.Прокурорын байгууллага, прокурор, ажилтны аюулгүй байдлыг хангах зорилгоор ашиглагдаж байгаа хяналтын камерт хяналт тавих.	Хяналтыг хэрэгжүүлсэн байна.	Х
	1.11.Хариуцсан ажлын мэдээ, тайланд дүн шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлт, үр дүнг тооцох.	Мэдээ, тайланд дүн шинжилгээ хийж, ажил, арга хэмжээний санал гаргасан байна.	Г, Х, Ш
	1.12.Хариуцсан ажлын чиглэлээр Улсын ерөнхий прокурорын дэргэдэх зөвлөлийн хуралдаанд асуудал хэлэлцүүлэн, шийдвэрлүүлэх.	Шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Г
	1.13.Нэгж прокурорын газарт хугацаатай үүрэг, даалгавар өгч, биелэлтэд хяналт тавих.	Үндэслэл бүхий үүрэг даалгавар өгч, үр дүнг тооцсон байна.	Г, Ш
	1.14.Ажлын явц, үр дүнгийн талаар Улсын ерөнхий прокурорыг мэдээллээр хангах.	Ажлын гүйцэтгэлийн шуурхай байдлыг хангаж, үнэн зөв мэдээллээр хангасан байна.	Г
	1.15.Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нараас өгсөн үүргийг хэрэгжүүлж, хариуцсан чиг үүрэгтэй холбоотой мэдээллээр хангах.	Үүрэг, даалгаврыг хэрэгжүүлж, мэдээллээр хангасан байна.	Г
	1.16.Хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан заавар, журам, Улсын ерөнхий прокурорын тушаалаар хариуцуулсан чиг үүргийг хэрэгжүүлэх.	Хууль, заавар, журамд заасан чиг үүрэг хэрэгжсэн байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	2.1.Прокурор, ажилтны сахилга хариуцлагын талаар гаргасан өргөдөл, гомдол, мэдээлэл болон хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр нийтлэгдсэн мэдээ, мэдээллийг прокуроруудад	Хяналт шалгалт явуулж, холбогдох арга хэмжээ авсан байна.	Г, Х

	хуваарилж, хяналт шалгалт явуулах.		
	2.2.Прокурор, ажилтан гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, сахилга, ёс зүйн зөрчил гаргасан шалтгаан нөхцөлийг судлах ажлыг зохион байгуулж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.	Шалтгаан нөхцөлийг судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байна.	Г, Х, Ш
	2.3.Зөрчил, гэмт хэргийн улмаас прокурор, ажилтан хохирсон тохиолдлыг судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.	Судалгаа хийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байна.	Г, Х, Ш
	2.4.Прокурорын ёс зүйн зөвлөлийн Ажлын албаны чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.	Ажлын албаны чиг үүргийг хэрэгжүүлсэн байна.	Х
	2.5.Хариуцсан чиг үүрэгтэй холбоотой асуудлаар байгууллагын эрх, хууль ёсны эрх ашиг сонирхлыг итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлөх.	Байгууллагын төлөөллийг хэрэгжүүлсэн байна.	Х
	2.6.Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах.	Дотоод аудит хийж, холбогдох арга хэмжээ авсан байна.	Х, Ш
3 дугаар зорилтын хүрээнд	3.1.Хэлтсийн прокурор, ажилтнуудыг мэргэжлийн удирдлагаар хангаж, гүйцэтгэлд хяналт тавих.	Хэлтсийн чиг үүрэг бүрэн хэрэгжих нөхцөл бүрдсэн байна.	Х
	3.2.Хэлтсийн шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулж, үүрэг даалгаврын биелэлт, үр дүнг тооцох.	Үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулсан байна.	Х, Ш
	3.3.Хэлтсийн хэмжээнд шаардлагатай бүртгэл, судалгааг хөтлүүлж, хяналт тавих.	Бүртгэл хөтлөлтөд хяналт тавьсан байна.	Х
	3.4.Хариуцсан ажилтай холбоотой мэдээ, мэдээлэл бэлтгэж, олон нийтэд хүргэх арга хэмжээ авах.	Мэдээ, мэдээллийг бэлтгэж, олон нийтэд хүргэсэн байна.	Х
	3.5.Хэлтсийн чиг үүрэгт хамаарах асуудлаар зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдтэй хамтран ажиллаж, бодлого, зорилтыг уялдуулах.	Ажлын уялдаа холбоог хангасан байна.	Г
	3.6.Архив, албан хэрэг хөтлөлтийн ажиллагаанд холбогдох хууль тогтоомж,	Хэрэгжилтийг хангасан байна.	Г, Х

	заавар, журам, стандартын хэрэгжилтийг хангах.		

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА		
Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	
Мэргэжил	Эрх зүй (0421)	
Мэргэшил	-хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээтэй байх -хуульчийн багц цагийн сургалтад хамрагдсан байх	
Туршлага	Прокуророор 5-аас доошгүй жил, үүнээс Улсын ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор, Нийслэлийн прокурорын газрын ерөнхий прокурорын орлогч, ахлах прокурор, сум дундын прокурорын газрын ерөнхий прокурор, аймаг, тээвэр, дүүргийн прокурорын газрын ерөнхий прокурор, ерөнхий прокурорын орлогчоор 3-аас доошгүй жил ажилласан байх.	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	-хэлтсийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх; -прокурор, ажилтанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх; -эрсдлийг урьдчилан тооцоолох, гарах арга замыг тодорхойлох, эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх.
	Дүн шинжилгээ хийх	-мэдээллийг цуглуулж, шалган нягтлах; -шийдвэрийн үр дагавар, эрсдлийг үнэлэх; -судалгааны арга зүйг ашиглан санал, дүгнэлт боловсруулах
	Асуудал шийдвэрлэх	-хариуцсан ажлын явцад үүссэн асуудал, хүндрэл бэрхшээлийн шалтгаан, нөхцөлийг бодит мэдээлэлд үндэслэн тогтоох; -шийдвэрийн үр дагавар эрсдлийг урьдчилан тооцоолох; -хууль тогтоомжид нийцсэн оновчтой шийдвэр гаргах; -гаргасан шийдвэрийн хариуцлагыг хүлээх.
	Манлайлах	-прокурор, ажилтнуудыг үлгэрлэн манлайлах; -ажлын байрны эерэг орчныг бүрдүүлэх; -шинэ санаачилга болон өөрчлөлтийг дэмжих.
	Багаар ажиллах	-хамтын шийдвэр гаргалтад идэвхтэй оролцох; -хариуцсан ажлыг багийн зорилготой уялдуулан хэрэгжүүлэх; -мэдээллийг нээлттэй хуваалцах; -бусдын санал бодлыг хүндэтгэх.
	Бусад	-баримт бичиг боловсруулах; -хууль хэрэглэх; -ажлын ачааллыг оновчтой төлөвлөж, эрэмбэлэн зохион байгуулах; -албан хэрэгцээнд шаардлагатай мэдээллийн систем, программ хангамжийг ашиглах, мэдээллийг цахим орчинд боловсруулах.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ	
<u>Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:</u> Улсын ерөнхий прокурор, түүний орлогч	
<u>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u> 1.Хэлтсийн хяналтын прокурор 2.Дотоод аудит хариуцсан референт 3.Хэлтсийн туслах ажилтан Нийт: 3	<u>Бусад харилцах субъект:</u> 1.Нэгж прокурорын газрын прокурор, ажилтан 2.Төрийн байгууллага 3.Иргэн, хуулийн этгээд

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ТУСЛАХ ПРОКУРОР, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХТУЯА 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдөр	Байгууллагын нэр: УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ДЭРГЭДЭХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН Шийдвэрийн огноо: 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Дугаар: 2
Албан тушаалын тодорхойлолт баталсан:	
Байгууллагын нэр: МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР Шийдвэрийн огноо: 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр Дугаар: А/95 УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР ТӨРИЙН ХУУЛЬ ЦАЗЫН ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ Б.ЖАРГАЛСАЙХАН 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр	